

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2022 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн: Б.Бейсен

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах, газрын нэгдсэн төлөвлөлт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг бий болгосны дараа газрыг өмчлүүлэх, өмчилсний дараа газрын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг зохицуулахаар уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд тариалангийн болон аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэхгүй, харин газрын нэгдмэл сангийн хот тосгон, бусад суурины ангилалд хамаарах газарт өмчлүүлэх, уг шийдвэрийг Засаг дарга бус аймаг нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, өөрийн хамаарах нутаг дэвсгэрт газар олголтыг зохион байгуулснаар шат дамжлага багасаж, газрын улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байгууллага хоорондын уялдаа, холбоо хангагдаж, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.САРАНЧИМЭГ